



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/241

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн ажил хөдөлмөр эрхлэх сонирхолтой ажилгүй, орлогогүй иргэдэд зориулж мэдлэг, ур чадвар олгох чуулга уулзалт зохион байгуулах зардалд 8,400,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 8,400,000 төгрөг (найман сая дөрвөн зуун мянга)-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 4.5-д тусгагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны  
04 дүгээр сарын 27-ны өдрийн  
А/241 дүгээр захирамжийн  
хавсралт



ХОВД АЙМГИЙН 200 АЖИЛТАН БЭЛТГЭХ СУРГАЛТАД ХЭРЭГЛЭГДЭХ МАТЕРИАЛЫН ЗАРДАЛ

Д/д	Нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Прусс мод	кв	20	135,000	2,700,000
2	Хадаас	хайрцаг	2	54,000	108,000
3	Шрүп	хайрцаг	20	5,500	110,000
4	Катанги төмөр	метр	14	2,500	35,000
5	Хар панерь мод	кв	20	55,000	1,100,000
6	Блок	кб	8	227,000	1,816,000
7	Тоосго	ширхэг	200	450	90,000
8	Элс	кб	5	125,000	625,000
9	Армотор	гр	200	3,600	720,000
10	Хэв хашмал фум	ширхэг	80	5,000	400,000
11	Бичиг хэргийн материал		1	696,000	696,000
	Нийт үнэ				8,400,000